

**ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ (ESEL)
СУРГАЛТЫН АРГАЗҮЙН БОЛОН ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮР ДҮНГИЙН
2 ТӨРЛИЙН ВИДЕО БҮТЭЭХ СТУДИ СОНГОН ШАЛГАРУУЛНА**

Товч танилцуулга:

Хүүхдийг Ивээх Сан Орон нутгийн өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох төслийг Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн санхүүжилт, Дэлхийн банкны менежментээр хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд Говьсүмбэр, Завхан, Ховд, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн зорилтот 25 сумын залуучууд, өсвөр үеийнхэнд Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалтыг (ESEL) Ерөнхий боловсролын сургууль, Насан түршийн суралцахуйн төв болон Мэргэжлийн боловсролын сургуулиудаар дамжуулан зохион байгуулдаг. Энэхүү сургалт нь хөдөө орон нутгийн өсвөр үеийн хүүхэд, залуусын бүтээлч, энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой бөгөөд сургалтад хамрагдсан хүүхэд, залуучууд баг болон бизнесийн санаагаа төсөл болгон, шалгуур хангасан багууд 3,500,000 хүртэлх төгрөгийн санхүүгийн тэтгэлэг авч, сургалтын үед эзэмшсэн мэдлэг, ур чадвараа бодит амьдрал дээр хөгжүүлдэг.

2024 оны 10-р сарын байдлаар 8773 хүүхэд, залуучууд ESEL сургалтад хамрагдаж, 1398 төгсөгч 343 бичил төслийг хэрэгжүүлж байна.

Сургалтын хэрэглэгдэхүүнүүд болох сургалтын хөтөлбөр, багшийн гарын авлага болон суралцагчийн гарын авлагыг доорх холбоосоор татаж авч үзнэ үү.

https://savethechildren.mn/?page_id=9830&lang=mn

Өмнөх танилцуулга болон амжилтын видеонуудыг доорхи холбоосоор үзнэүү.

[Save the Children in Mongolia - YouTube](#)

Гэрээт ажлын зорилго:

1. Төслийн хүрээнд явагдаж буй Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалтын (ESEL) арга зүйн онцлогийг багш нарт танилцуулах зорилготой 1 видео
2. 2019-2025 оны хооронд хэрэгжиж буй Орон нутгийн өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох төслийн эцсийн үр дүн, амжилтын тухай 1 видео, нийт **2 төрлийн видео бүтээл** хийж гүйцэтгэнэ.

Видео бүтээлд тавигдах нийтлэг шаардлага:

- Видео тус бүрийг тухайн видеоны онцлогт тохирсон зохиомж, шийдлээр бүтээх;
- 1-р видео бүтээлийн хугацаа 8-10 минут, 2-р видео бүтээлийн хугацаа 10-12 минут байх;
- Зохиол нэг бүрийг батлуулсны дараа зураг авалтын ажлаа эхлэх;
- Видео зохиол, өгүүлэмж нь шинэлэг, сонирхолтой, бүтээлч байх;
- Өмнө нь бүтээсэн төслийн болон сургалтын танилцуулга видеотой уялдсан байна.
- Бүтээлийн агуулгыг дэмжсэн сонирхолтой график дүрслэл, схем зураглал, тоо баримт ашиглах;

- Видеоны зохиомж, найруулга, график, зураг, эвлүүлгийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэсэн байх;
- Видео тус бүр дээр дохионы хэлний орчуулга оруулсан байх;
- Видео тус бүрийг англи хэл дээр орчуулж, орчуулгыг хадмал тест хэлбэрээр видеонд оруулсан хувийг тусад нь хүлээлгэн өгөх;
- Хүүхдийг Ивээх Сангийн брэндингийн дагуу гүйцэтгэнэ.
- Текстийг мэргэжлийн диктор уншсан байна.
- Зохиогчийн эрх, бусдын оюуны өмчийн эрхийн зөрчилгүй байна.
- Видеоог MP4 форматаар хүлээлгэж өгнө.

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

- Видео контент бүтээх салбарт багадаа 3 жил ажилласан туршлагатай байх,
- Телевизийн нэвтрүүлэг, анимейшн, баримтат кино бүтээх, зураг авалт, найруулгыг өндөр түвшинд хийх мэргэжлийн боловсон хүчин, бие даасан өөрийн эзэмшлийн студитэй байх,
- Телевизийн нэвтрүүлэг, баримтат кино бүтээх сүүлийн үеийн үзүүлэлт бүхий мэргэжлийн тоног төхөөрөмжтэй байх,
- Шинэлэг, бүтээлчээр хандах чадвартай уран бүтээлчдийн багтай байх.

Ажил гүйцэтгэх хугацаа:

Тус ажлыг 2024 оны 10 дугаар сарын 28-өөс 2025 оны 02 дүгээр сарын 28-ны дотор дараах ерөнхий хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

№	Гүйцэтгэх ажил	Дуусах хугацаа
1	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	2024 оны 10 сарын 28
2	Захиалгат ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө хүлээлгэн өгөх	2024 оны 11 сарын 01
3	Видео-1, Видео-2 -ын зохиолыг эцэслэх, санал солилцох, захиалагч талаас зөвшөөрөл авах	2024 оны 11 сарын 08
ВИДЕО-1		
4	Видео-1 -ийн дүрс бичлэг хийх (Видео-2-ын зарим дүрс бичлэгийг хамт хийнэ), дуу оруулах, эвлүүлэг монтаж, график дизайн хийх ажлуудыг хийж гүйцэтгэх	2024 оны 12 сарын 06
5	Видео-1 -ийн эхний хувилбарыг илгээж, санал солилцох	2024 оны 12 сарын 13
6	Видео-1: Англи хадмал орчуулга оруулсан видео болон дохионы хэлний орчуулга оруулсан Монгол видеог эцэслэн хүлээлгэж өгөх	2024 оны 12 сарын 27
ВИДЕО-2		
7	Видео-2 нэмэлт дүрс бичлэг хийх, дуу оруулах, эвлүүлэг монтаж, график дизайн хийх ажлуудыг хийж гүйцэтгэх	2025 оны 01 сарын 27
8	Видео-2 эхний хувилбарыг илгээж санал солилцох	2025 оны 02 сарын 10
9	Видео-2 Англи хадмал орчуулга оруулсан видео болон дохионы хэлний орчуулга оруулсан Монгол видеог эцэслэн хүлээлгэж өгөх	2025 оны 02 сарын 28

Ирүүлэх материалууд:

- Ажлыг хийж гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн албан бичиг, байгууллагын гэрчилгээ

- Ажлыг хэрхэн хийж гүйцэтгэх санал, төлөвлөгөө
- Үнийн санал, төсвийн задаргаа
- Өмнө хийж байсан ижил төрлийн бүтээлүүдийн жагсаалт, линк

Дээрх материалуудыг бэлтгэж, гүйцэтгэгчид тавих шаардлагыг хангаж байгаагаа нотолсон баримт нотолгооны хамт 2024 оны 10 дугаар сарын 22-ний 17.00 цагаас өмнө доорх хаягаар БИТҮҮМЖЛЭН ирүүлнэ үү.

Санал ирүүлэх хаяг:

ЯПОНЫ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

1-р хороо, Аризона төвийн 4-р давхарт

Утас: 329365, 329371